ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/001/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Зуунмод 2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитор Б.Нямсүрэн
Утас: 70272248 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tov@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.16 № 01/85

танай ______________-ны № __________________-т

ТӨВ АЙМГИЙН СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Ч.ОТГОНЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Байгууллагын үйл ажиллагааг танилцуулах контент хийх гэрээнд үр дүн, тайланг хүлээлцээгүй, гэрээ дүгнэх хугацааг тодорхой тусгаагүй;
- Дотоод албан томилолтын зардлаас хоолны хөнгөлөлтийн дүнг суутгаагүй;

зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8, Хувь хүний орлогын татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн А/96 дугаар тушаалаар аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн бүтэц, орон тоог 21 орон тоотойгоор баталсан байна. Тайлант онд хэлтсийн дарга 1, төрийн

41'00'0085

захиргааны албан хаагч 8, төрийн үйлчилгээний албан хаагч 12, нийт 21 орон тоотой ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Тус хэлтэс нь Язгуур Контент ХХК-тай хамтран байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилготой мэдээ мэдээлэл түгээх 20 мэдээ 4,000.0 мянган төгрөг, 3 удаагийн подкаст 6,000.0 мянган төгрөг, нэг удаагийн подкастаас 5 рийл 1,500.0 мянган төгрөг, 10 постер 1,000.0 мянган төгрөг, мэдээг сайт дээр байршуулах 3 мэдээлэл 1,000.0 мянган төгрөг, стандартын тухай залуучуудад хандсан нөлөөллийн постер 1,500.0 мянган төгрөг нийт 15,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 14 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 98,8 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 40,976,952.57 | 377,909,341.55 |
| 33 | АВЛАГА | 3,186,209.90 | 357,535,559.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 600,000.00 | 600,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 346,435,559.00 |
| 335 | Бусад авлага | 2,586,209.90 | 10,500,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 2,586,209.90 | 10,500,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 37,790,742.67 | 20,373,782.55 |
| 351 | Түүхий эд материал | 24,373,617.67 | 16,422,311.55 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 8,909,538.00 | 4,888,528.00 |
| 35130 | Эм боох материал | 15,464,079.67 | 11,533,783.55 |
| 354 | Хангамжийн материал | 13,417,125.00 | 3,951,471.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 302,700.00 | 297,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,009,906.00 | 1,192,370.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,047,400.00 | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 1,120,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 116,600.00 | 116,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,940,519.00 | 1,224,801.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 153,226,411.36 | 175,821,140.63 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 153,226,411.36 | 175,821,140.63 |
| 392 | Биет хөрөнгө | 131,986,411.36 | 154,581,140.63 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 85,363,236.00 | 85,363,236.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (44,432,949.96) | (55,103,354.52) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 14,800,000.00 | 14,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (14,800,000.00) | (14,800,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 139,825,714.00 | 203,808,514.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (56,206,219.04) | (86,189,326.37) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 16,373,373.00 | 17,765,410.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,936,742.64) | (11,063,338.98) |
| 393 | Биет бус хөрөнгө | 21,240,000.00 | 21,240,000.00 |
| 39301 | Програм хангамж | 500,000.00 | 500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (500,000.00) | (500,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 21,240,000.00 | 21,240,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **194,203,363.93** | **553,730,482.18** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,254,139.00 | 20,927,689.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,254,139.00 | 20,927,689.00 |
| 413 | Өглөг | 1,254,139.00 | 20,927,689.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 680,000.00 | 18,054,050.00 |
| 4136 | Бусад өглөг | 574,139.00 | 2,873,639.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 574,139.00 | 1,574,139.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 1,299,500.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 192,949,224.93 | 532,802,793.18 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 192,949,224.93 | 532,802,793.18 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 130,292,927.00 | 130,292,927.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 130,292,927.00 | 130,292,927.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 9,883,294.93 | 349,736,863.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 9,883,294.93 | 9,883,294.93 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 339,853,568.25 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 52,773,003.0 | 52,773,003.0 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **194,203,363.9** | **553,730,482.2** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **871,973,384.00** | **1,261,405,275.07** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 110,582,183.00 | 499,245,475.87 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 110,582,183.00 | 499,245,475.87 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 109,683,683.00 | 495,389,275.87 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 109,683,683.00 | 451,435,559.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 600,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 761,391,201.00 | 762,159,799.20 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 607,687,600.00 | 730,884,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 607,687,600.00 | 730,884,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 153,703,601.00 | 31,275,399.20 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,758,881.00 | 31,275,399.20 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,500,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 76,444,720.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **897,879,208.78** | **918,769,846.82** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 897,879,208.78 | 918,769,846.82 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 737,252,894.72 | 875,790,146.94 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 485,710,299.51 | 576,323,441.07 |
| 210101 | Үндсэн цалин | 246,791,622.05 | 314,494,303.20 |
| 210102 | Нэмэгдэл | 203,607,077.46 | 162,519,887.87 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,064,800.00 | 55,314,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,246,800.00 | 43,995,250.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 65,839,564.94 | 73,837,417.52 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,257,676.08 | 49,465,816.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,971,937.19 | 5,594,840.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,685,808.97 | 4,564,960.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,446,368.65 | 2,752,540.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,477,774.05 | 11,459,260.25 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 74,538,193.88 | 97,750,052.63 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,191,172.94 | 5,557,326.56 |
| 210302 | Түлш, халаалт | 68,805,315.94 | 90,506,921.07 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,541,705.00 | 1,685,805.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,943,810.00 | 10,392,586.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,071,700.00 | 2,956,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,180,000.00 | 2,680,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,357,560.00 | 1,878,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 323,700.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,010,850.00 | 2,697,386.00 |
| 2105 | Нормативт зардал | 18,581,099.21 | 20,808,884.12 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 15,116,879.21 | 18,973,934.12 |
| 210502 | Хоол, хүнс | 3,464,220.00 | 1,751,950.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 83,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,911,844.00 | 2,517,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 794,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,911,844.00 | 1,723,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 21,034,000.00 | 30,180,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,034,000.00 | 30,180,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,825,728.00 | 18,681,978.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 735,700.00 | 13,200,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 451,300.00 | 449,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 34,928.00 | 34,928.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 490,500.00 | 2,052,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 91,300.00 | 2,923,850.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,868,355.18 | 45,298,687.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,026,700.00 | 3,482,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,419,000.00 | 600,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43,422,655.18 | 41,216,387.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 160,626,314.06 | 42,979,699.88 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 138,196,315.00 | 32,543,677.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 51,640,765.00 | 32,543,677.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 46,016,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 40,539,550.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 22,357,289.73 | 10,436,022.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,357,289.73 | 10,436,022.88 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 72,709.33 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 72,709.33 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (25,905,824.78) | 342,635,428.25 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **555,400.00** | **2,781,860.00** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **871,074,884.00** | **1,214,195,358.20** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 109,683,683.00 | 452,035,559.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 109,683,683.00 | 452,035,559.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 109,683,683.00 | 452,035,559.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 109,683,683.00 | 451,435,559.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 600,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 761,391,201.00 | 762,159,799.20 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 607,687,600.00 | 730,884,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 607,687,600.00 | 730,884,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 153,703,601.00 | 31,275,399.20 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,758,881.00 | 31,275,399.20 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,500,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 76,444,720.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **871,074,884.00** | **1,214,195,358.20** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 871,074,884.00 | 1,214,195,358.20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 710,448,569.94 | 826,079,599.32 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 494,246,202.07 | 573,854,129.14 |
| 210101 | Үндсэн цалин | 293,691,801.84 | 303,047,937.20 |
| 210102 | Нэмэгдэл | 159,573,544.95 | 171,496,941.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,064,800.00 | 55,314,000.00 |
| 210104 | Урамшуулал | 19,916,055.28 | 43,995,250.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 65,866,872.84 | 73,720,519.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,303,011.81 | 50,824,900.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,387,990.29 | 5,615,175.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,888,782.75 | 3,028,231.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,513,094.51 | 2,752,281.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,773,993.48 | 11,499,931.10 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 77,986,493.03 | 97,750,052.63 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,191,172.94 | 5,557,326.56 |
| 210302 | Түлш, халаалт | 72,253,615.09 | 90,506,921.07 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,541,705.00 | 1,685,805.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,110,110.00 | 8,495,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,653,180.00 | 1,834,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,981,000.00 | 3,980,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,353,380.00 | 1,878,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 323,700.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 798,850.00 | 622,150.00 |
| 2105 | Нормативт зардал | 14,539,920.00 | 9,223,870.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,075,700.00 | 7,494,920.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3,464,220.00 | 1,645,950.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 83,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,172,144.00 | 21,155,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 19,918,400.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 794,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,172,144.00 | 443,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 27,850,000.00 | 14,670,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 27,850,000.00 | 14,670,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,796,428.00 | 25,262,928.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 735,700.00 | 22,700,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 451,300.00 | 449,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 34,928.00 | 34,928.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 539,000.00 | 2,052,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 13,500.00 | 4,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,880,400.00 | 1,947,250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,425,400.00 | 1,347,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,455,000.00 | 600,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 160,626,314.06 | 388,115,758.88 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 138,196,315.00 | 31,244,177.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 51,640,765.00 | 31,244,177.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 46,016,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 40,539,550.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 22,357,289.73 | 10,436,022.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,357,289.73 | 10,436,022.88 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 72,709.33 | 346,435,559.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 72,709.33 | 346,435,559.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 130,292,927.00 | 52,773,003.00 | 39,299,449.33 | 222,365,379.33 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 130,292,927.00 | 52,773,003.00 | 39,299,449.33 | 222,365,379.33 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (26,461,224.78) | (26,461,224.78) |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 130,292,927.00 | 52,773,003.00 | 9,883,294.93 | 192,949,224.93 |
| D01 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 130,292,927.00 | 52,773,003.00 | 9,883,294.93 | 192,949,224.93 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 130,292,927.00 | 52,773,003.00 | 9,883,294.93 | 192,949,224.93 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 339,853,568.25 | 339,853,568.25 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 130,292,927.00 | 52,773,003.00 | 349,736,863.18 | 532,802,793.18 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **0** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **848,408,200.00** | **1,182,319,959.00** | (333,911,759.00) | 139.36 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 741,191,800.00 | 730,884,400.00 | 10,307,400.00 | 98.61 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 741,191,800.00 | 730,884,400.00 | 10,307,400.00 | 98.61 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 107,216,400.00 | 451,435,559.00 | (344,219,159.00) | 421.05 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 107,216,400.00 | 451,435,559.00 | (344,219,159.00) | 421.05 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 21.00 | 21.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 8.00 | 8.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 12.00 | 12.00 | - | 100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **848,408,200.00** | **825,448,377.12** | 22,959,822.88 | 97.29 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 848,408,200.00 | 825,448,377.12 | 22,959,822.88 | 97.29 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 817,164,000.00 | 794,204,200.12 | 22,959,799.88 | 97.19 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 548,284,300.00 | 546,051,327.08 | 2,232,972.92 | 99.59 |
| 210101 | Үндсэн цалин | 304,855,900.00 | 303,047,937.20 | 1,807,962.80 | 99.41 |
| 210102 | Нэмэгдэл | 141,128,300.00 | 143,694,139.88 | (2,565,839.88) | 101.82 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 56,199,600.00 | 55,314,000.00 | 885,600.00 | 98.42 |
| 210104 | Урамшуулал | 46,100,500.00 | 43,995,250.00 | 2,105,250.00 | 95.43 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 71,568,600.00 | 70,247,922.41 | 1,320,677.59 | 98.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,666,700.00 | 48,436,934.66 | 229,765.34 | 99.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,725,500.00 | 5,353,797.04 | 371,702.96 | 93.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,862,700.00 | 2,887,115.45 | (24,415.45) | 100.85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,862,700.00 | 2,632,018.48 | 230,681.52 | 91.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,451,000.00 | 10,938,056.78 | 512,943.22 | 95.52 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 100,228,400.00 | 97,750,052.63 | 2,478,347.37 | 97.53 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,852,900.00 | 5,557,326.56 | 295,573.44 | 94.95 |
| 210302 | Түлш, халаалт | 90,507,000.00 | 90,506,921.07 | 78.93 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,868,500.00 | 1,685,805.00 | 2,182,695.00 | 43.58 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,488,800.00 | 8,495,050.00 | 1,993,750.00 | 80.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,996,500.00 | 1,834,200.00 | 162,300.00 | 91.87 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,483,500.00 | 3,980,000.00 | 503,500.00 | 88.77 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,544,900.00 | 1,878,700.00 | 666,200.00 | 73.82 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 322,800.00 | 180,000.00 | 142,800.00 | 55.76 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,141,100.00 | 622,150.00 | 518,950.00 | 54.52 |
| 2105 | Нормативт зардал | 14,427,700.00 | 9,223,870.00 | 5,203,830.00 | 63.93 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 9,977,100.00 | 7,494,920.00 | 2,482,180.00 | 75.12 |
| 210502 | Хоол, хүнс | 3,454,800.00 | 1,645,950.00 | 1,808,850.00 | 47.64 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 995,800.00 | 83,000.00 | 912,800.00 | 8.34 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 23,215,600.00 | 21,155,800.00 | 2,059,800.00 | 91.13 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,918,400.00 | 19,918,400.00 | - | 100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,833,500.00 | 794,000.00 | 2,039,500.00 | 28.02 |
| 210604 | Урсгал засвар | 463,700.00 | 443,400.00 | 20,300.00 | 95.62 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 14,780,000.00 | 14,670,000.00 | 110,000.00 | 99.26 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,780,000.00 | 14,670,000.00 | 110,000.00 | 99.26 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,370,400.00 | 25,262,928.00 | (20,892,528.00) | 578.05 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 22,700,000.00 | (22,700,000.00) | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 449,200.00 | 449,200.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 173,800.00 | 34,928.00 | 138,872.00 | 20.10 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,100.00 | 22,000.00 | 8,100.00 | 73.09 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,346,100.00 | 2,052,000.00 | 1,294,100.00 | 61.33 |
| 210807 | Газрын төлбөр | 62,500.00 | - | 62,500.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 10,000.00 | - | 10,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 298,700.00 | 4,800.00 | 293,900.00 | 1.61 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,800,200.00 | 1,347,250.00 | 28,452,950.00 | 4.52 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,800,200.00 | 1,347,250.00 | 28,452,950.00 | 4.52 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 31,244,200.00 | 31,244,177.00 | 23.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 31,244,200.00 | 31,244,177.00 | 23.00 | 100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,244,200.00 | 31,244,177.00 | 23.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 152,821,891.67 | 31,875,399.20 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 152,821,891.67 | 31,875,399.20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 112,821,891.67 | 31,875,399.20 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,206,537,974.00 | 27,802,802.06 |
| 210102 | Нэмэгдэл | 25,498,819.22 | 27,802,802.06 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,267,372.84 | 3,472,597.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,815,411.81 | 2,387,965.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 859,990.29 | 261,378.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 624,782.75 | 141,115.72 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 249,094.51 | 120,263.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,718,093.48 | 561,874.32 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 600,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 600,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 152,821,891.67 | 31,275,399.20 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 152,821,891.67 | 31,275,399.20 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Залруулагдаагүй нийт 32,707.2 мянган төгрөгийн зөрчлөөс 11,469.0 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,041.3 мянган төгрөгөөр давсан тул **“Хязгаарлалттай”** дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 32,707.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 969.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 10,500.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч, 21,238.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд 14,670.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардал гарснаас 67 өдрийн 969.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийн дүнг суутгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно." гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Тайлант оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 183 мэдээллийг мэдээлэхээс 7 мэдээлэл хугацаа хоцроосон ба өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэр, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна. Мөн өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 5 дугаар зүйлийн 5.1-т “Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухайн хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тайлант онд тушаал шийдвэргүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй "Язгуур контент" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж байгууллагын үйл ажиллагааг танилцуулах зорилгоор 20 удаагийн мэдээ, 3 подкаст, 5 рийл, 10 постер, сард 3 мэдээлэл нийтлэх ажлын даалгавартай 15,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч тус байгууллагын тухай мэдээ мэдээлэл тавигдаагүй ба ажил хүлээлцэх хугацааг тодорхой гэрээнд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

**5.3 Зөвлөмж**

1. Татвар, торгуультай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>*

Тус байгууллагын дансанд бүртгэлтэй 8564ТӨА улсын дугаартай тээврийн хэрэгсэл нийт 490.0 мянган төгрөгийн торгуультай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Монгол Улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2-т “Аж ахуйн нэгж, байгууллага авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор багтаан төсөвт төлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Цаашид татварыг цаг хугацаанд нь төлж байх, торгууль гаргасан этгээдийг тогтоож төлүүлэх.

2. Өр төлбөр данстай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>*

Тус байгууллага нь тайлант онд 16,190.0 мянган төгрөгийн томилолтын өглөг, 3,438.2 мянган төгрөгийн байгууллагатай холбогдсон өглөг, нийт 19,628.2 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

3. Бараа материал данстай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>*

Тус байгууллага нь Түлш, шатах тослох материалын 1,120.0 мянган төгрөгийн нөөц бүрдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заалтыг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Цаашид нөөцлөх шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр нөөцлөхгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | То о | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тус байгууллагын дансанд бүртгэлтэй 8564ТӨА улсын дугаартай тээврийн хэрэгсэл нийт 490.0 мянган төгрөгийн торгуультай байна. | 1 | 490.0 | | | | | 1 | 490.0 |
| Тус байгууллага нь тайлант онд 16,190.0 мянган төгрөгийн томилолтын өглөг, 3,438.2 мянган төгрөгийн байгууллагатай холбогдсон өглөг, нийт 19,628.2 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. | 1 | 19,628.2 | | | | | 1 | 19,628.2 |
| Тус байгууллага нь Түлш, шатах тослох материалын 1,120.0 мянган төгрөгийн нөөц бүрдүүлсэн байна. | | | | | | | 1 | 1,120.0 |
| Тайлант оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 183 мэдээллийг мэдээлэхээс 7 мэдээлэл хугацаа хоцроосон ба өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэр, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна. Мөн өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна | 1 | - | | | 1 | - | | |
| Тайлант онд тушаал шийдвэргүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй "Язгуур контент" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж байгууллагын үйл ажиллагааг танилцуулах зорилгоор 20 удаагийн мэдээ, 3 подкаст, 5 рийл, 10 постер, сард 3 мэдээлэл нийтлэх ажлын даалгавартай 15,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч тус байгууллагын тухай мэдээ мэдээлэл тавигдаагүй ба ажил хүлээлцэх хугацааг тодорхой гэрээнд тусгаагүй байна. | 1 | 10,500.0 | | | 1 | 10,500.0 | | |
| Тайлант онд 14,670.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардал гарснаас 67 өдрийн 969.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийн дүнг суутгаагүй байна. | 1 | 969.0 | 1 | 969.0 | | | | |
| Дүн | **6** | **32,707.2** | **1** | **969.0** | **2** | **10,500.0** | **3** | **21,238.2** |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас:  +976  70272582,  +976  70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn